

ШИНЭ БҮТЭЭЛ ХЭВЛЭГДЛЭЭ

Тусхүрээлэнгийн Европ судлалын секторын эрхлэгч, доктор Д. Золбоогийн “Монгол, Британий харилцаа” номын хянан сайжруулсан хоёр дахь хэвлэл хэвлэгдэн гарч уншигч олны гар дээр очлоо.

Монгол, Британий харилцааны түүхэн замналыг нарийвчлан судлах нь Монгол Улсын орчин цагийн түүх болон ерөөс олон улсын харилцаа, орон судлалд үлэмж ач холбогдолтой юм. Энэ үүднээс тэрээр Монгол, Британий харилцааны ХХ зууны түүхэн үйл явцыг тал бүрээс нь цогц байдлаар нэгэн сэдэвт зохиолын хэмжээнд судлах оролдлого тэрээр хийжээ. Чингэж эл сэдвийг эрдэм судлалын ажлынхаа үндсэн судлагдахуун болгосон сонгон авч, судлан боловсруулах нь онол практикийн хувьд ч ач холбогдолтой юм. Судалгааны ажлын хүрээг он цагийн хувьд гурав үечлэн авч үзэж, агуулгын хувьд улс төрийн харилцаа, худалдаа, эдийн засаг, зээл тусламж хийгээд түүнчлэн боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэнд, хүмүүнлэг, олон нийтийн зэрэг тодорхой салбар тус бүрийн өвөрмөц онцлог бүхий хэлхээ холбоо, харилцан ажиллагааны чиглэлийг голлон тусгахад анхаарчээ. Монгол, Британий харилцааны үйл явцыг тухайн үеийн олон улсын нөхцөл байдлын онцлогтой нягт уялдуулан авч үзэн, дүн шинжилгээ хийх оролдлого хийхийг хичээсэн байна. Ялангуяа сүүлийн 20 гаруй жилд Британи улстай тогтоосон харилцаа бүх чиглэлээр өргөжин бэхжсэн нь Азид чиглэсэн Британий гадаад бодлого, геополитикийн үүрэг ролийг эрс өсгөсөн төдийгүй Монгол Улсын олон улсын байр суурийг бэхжүүлэх, түүний гадаад бодлогыг улам идэвхжүүлж, илүү нээлттэй, үр ашигтай болгоход ихээхэн тус дөхөм үзүүлсэн ба үзүүлж байна гэсэн чухал үнэлэлт, дүгнэлт гаргасан байна. Энэхүү зохиолоо тэрбээр Монгол Улсын ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, Монгол Улсын Их сургуулийн зарим сургуулийн эрдмийн зөвлөл, эрдэмтдийн хамтлагаар хэлэлцүүлж, санал шүүмжийг нь соргоогоор тусган, эрдэмтэн судлаач, их, дээд сургуулийн багш, оюутан, Монгол, Британий харилцаанд оролцдог бүх талууд, өргөн олон уншигч түмний хүртээл болгохыг зөвлөсний дагуу хэвлэн нийтэлж байгааг нь болгоон соёрхоно уу.

Тэрээр Монгол, Британий хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойд уг бүтээлээ зориулсан бөгөөд ойн арга хэмжээг тэмдэглэх Монгол Улсын Засгийн газрын ажлын хорооны нарийн бичгийн даргаар томилогдсон байна. Энэхүү ажлын хороо нь 23 хүн бүхий өргөн бүрэлдэхүүнтэй уг хорооны даргаар Гадаад харилцааны сайд, дэд даргаар УИХ-ын Монгол, Британий бүлгийн дарга ажиллах бөгөөд Гадаад харилцааны болон бусад 10 яамны төрийн нарийн бичгийн дарга болон Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга нар, ШУА-ийн Ерөнхийлөгч, Үндэсний төв архивын захирал, Гадаад харилцааны төв архивын дарга зэрэг албаны хүмүүс багтсан байна.